



№ 18

ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6, 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.7, 8.6.11 дэх заалт, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 02 дугаар тогтоол, “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 21/01 тоот удирдамж “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоол, 2021 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн “Өрийн бичгийг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Өрийн бичгийг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авахтай холбоотой үнэт цаас гаргагчийн эрх, үүргийг журамд заасны дагуу хэрэгжүүлж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ү.Амарбат)-д даалгасугай.



100000072



ӨРИЙН БИЧГИЙГ ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНААС ӨМНӨ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-аас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, компанийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцлийг бүрдүүлэхэд зориулан гаргах 2.0 (Хоёр их наяд) хүртэлх төгрөгийн бондыг хугацаанаас өмнө эргүүлэн дуудаж, бонд эзэмшигчээс эргүүлэн худалдан авахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү харилцаанд Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмуудыг удирдлага болгоно.

ХОЁР. ХУГАЦААНААС ӨМНӨ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ, ДУУДАХ НӨХЦӨЛ

- 2.1 Үнэт цаас гаргагч нь энэхүү бондтой ижил төстэй санхүүгийн хэрэгслийн хүү зах зээл дээр буурч, бондын хүүнээс бага болсон тохиолдолд бондыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь эргүүлэн дуудахаар шийдвэрлэж болно.
- 2.2 Бондын анхдагч зах зээлийн арилжаа дуусаж бондыг эзэмшсэн хугацаа тооцогдож эхэлснээс хойш 1 жил өнгөрсний дараа Үнэт цаас гаргагч нь бондыг эргэн дуудах эрх үүснэ.
- 2.3 Үнэт цаас гаргагч бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн дуудах ажиллагааг хагас жил тутамд хэрэгжүүлж болно.
- 2.4 Бондыг хугацаанаас өмнө эргүүлэн дуудах шийдвэрийг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- 2.5 Бондыг эргүүлэн дуудах шийдвэр нь тухайн төрөл тус бүрээр бүхэлд нь дуудах нөхцөлтэй байна.
- 2.6 Тодорхой төрлийн бондыг хамтад нь эргүүлэн дуудаж болно.
- 2.7 Энэхүү журмын 2.4-д заасан шийдвэрт худалдан авах бондын төрөл, эргүүлэн худалдан авах дүн, хугацааг тусгах ба бусад нөхцөлийг энэхүү журмаар зохицуулна.

- 2.8. Үнэт цаас гаргагчаас бондыг эргүүлэн дуудахаар шийдвэрлэсэн бол бонд эзэмшигч бондоо Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах үүрэгтэй.
- 2.9. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.
- 2.10. Үнэт цаас гаргагч нь дор дурдсан нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авч болно.
 - 2.10.1. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа худалдан авах буюу эргүүлэн худалдан авмагц шууд төлбөрийн чадвартай байх;
 - 2.10.2. Үнэт цаас гаргагчийн сүүлийн балансад тусгагдсан өөрийн хөрөнгийн хэмжээ нь дүрэмд заасан хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийн хэмжээ болон давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үеийн үнэ зэргийн нийлбэрээс их байх.
- 2.11. Бондын эргэн дуудах үнэ:
 - Төгрөгийн бондын нэгжийн үнэ: 101,500 төгрөг.
 - Ам.долларын бондын нэгжийн үнэ: 101 ам.доллар.

ГУРАВ. ЭРГҮҮЛЭН ДУУДАХ АЖИЛЛАГААГ ГҮЙЦЭТГЭХ

- 3.1. Үнэт цаас гаргагч нь бондыг эргүүлэн дуудахаас 1 сарын өмнө бонд эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 3.2. Энэхүү мэдэгдэлд бондын төрөл, эргүүлэн дуудах бүртгэлийн өдөр болон бусад шаардлагатай мэдээллийг заасан байна.
- 3.3. Үнэт цаас гаргагч нь Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох хүсэлт илгээн бүртгэлийн өдрөөс 2-оос доошгүй хоногийн өмнө бондын хоёрдогч зах зээлийн арилжааг зогсоох тухай асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.4. Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн бонд эзэмшигчдийн судалгаанд үндэслэн бондын үндсэн төлбөрийг энэхүү журмын 2.11-д заасан үнээр тооцон тухайн өдөр хүртэлх эзэмшсэн хугацааны хүү зэрэг мэдээллийг бонд эзэмшигч тус бүрээр гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хүргүүлнэ.
- 3.5. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 3.4-т зааснаар тооцсон бондын үндсэн төлбөрийг хүүгийн хамт бүртгэлийн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан бонд эзэмшигчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх үнэт цаасны дансанд шилжүүлнэ.
- 3.6. Бондыг эргүүлэн дуудах бүртгэлийн өдрийн байдлаар бондыг эзэмшиж буй этгээд нь энэхүү журмын 3.4-д заасан үндсэн болон хүүний төлбөрийг авах эрхтэй байна.

- 3.7. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 3.5-д заасан хугацаанд бондын төлбөрийг бүрэн төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд тухайн төлөгдөөгүй төлбөрийн 0.02%-р алданги тооцон төлбөрийн хамт бонд эзэмшигчид төлнө.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг

- 4.1.1. Хугацаанаас эргүүлэн дуудахаас 1 сарын өмнө бонд эзэмшигчид мэдэгдэх үүрэгтэй.
- 4.1.2. Бондыг эргүүлэн дуудаж энэхүү журмын дагуу үндсэн болон хүүгийн төлбөрийг бонд эзэмшигчид төлөх үүрэгтэй.
- 4.1.3. Бондыг эргүүлэн дуудах ажиллагаатай холбогдон гарах Үнэт цаас гаргагчид хамаарах эрх бүхий байгууллагын шимтгэл, төлбөр болон бусад татвар хураамжийг хариуцан төлөх үүрэгтэй.
- 4.1.4. Хувь хүний орлогын татварын тухай хуулийн дагуу бондын үндсэн болон хүүгийн төлбөрөөс хувь хүний орлогын албан татварыг суутган шилжүүлэх эрхтэй.

4.2. Бонд эзэмшигчийн эрх үүрэг

- 4.2.1. Үнэт цаас гаргагчаас бондыг эргүүлэн дуудахаар шийдвэрлэсэн бол бонд эзэмшигч бондоо Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах үүрэгтэй байна.
- 4.2.2. Бонд эзэмшигч нь бондыг эргүүлэн дуудах ажиллагаатай холбогдон гарах өөрт хамаарах эрх бүхий байгууллагын шимтгэл, төлбөр болон бусад татвар хураамжийг хариуцан төлнө.
- 4.2.3. Бондыг эргүүлэн дуудах нөхцөлд заасан хугацаанд энэхүү журмын дагуу тооцогдсон хүүгийн болон үндсэн төлбөрийг төлөхийг шаардах эрхтэй.

-- oo O oo --